

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ ХУЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 07 дугаар сарын 04-ний өдөр баталсан Прокурорын байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Прокурорын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

“7.Прокуророор 25-аас доошгүй жил ажилласан, эсхүл прокуророор 20-оос доошгүй жил ажилласан тавин насанд хүрсэн эмэгтэй, тавин таван насанд хүрсэн эрэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Прокурорын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.1.14 дэх заалт нэмсүгэй:

“41.1.14.прокурор төр, нийтийн эрх ашгийг төлөөлөн иргэний болон бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлүүлэхээр гаргасан нэхэмжлэл.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Прокурорын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг